

НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН ГЭРЭЭ

2021 оны 05 сарын 14 өдөр

Дугаар 03

Налайх дүүрэг

Гэрээний зорилго: Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагад "Хөдөлмөрийн тухай", "Байгаль орчныг хамгаалах тухай", "Ашигт малтмалын тухай", "Хог хаягдлын тухай", "Зөрчлийн тухай" "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай", "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай" хууль холбогдох дүрэм, журам, дүүргийн удирдлагаас гарсан тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг хангуулж, төр захиргааны эрх бүхий байгууллагаас дэмжлэг үзүүлэн, хяналт тавих, нөгөө талаас сайн дурын үндсэн дээр орон нутгийн хөгжилд оруулах хувь нэмрийн хүрээнд нийгмийн хариуцлагыг тодорхойлж, хамтран ажиллахтай холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.

Нэг. Ерөнхий зүйл

Нэг талаас Дүүргийн удирдлагыг төлөөлж Налайх дүүргийн Засаг даргын орлогч С.Тунгалаг (цаашид "Захиргааны байгууллага" гэх), нөгөө талаас Аж ахуйн нэгж, байгууллагыг төлөөлж Налайх дүүргийн 5 хорооны нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа 256166.2 регистрийн дугаартай, "Меру" ХХК-ийн захирал Т.Батхуу (цаашид "ААН, байгууллага" гэх) нар нь хамтран дараах нөхцлүүдийг хэлэлцэн тохиролцож, харилцан зөвшөөрснөөр энэхүү гэрээг байгуулав.

- 1.1. Талууд бие биенийхээ үйл ажиллагааг харилцан хүндэтгэж, гэрээний заалтуудыг чанд мөрдөнө.
- 1.2. Гэрээг 2% үйлдэж, хоёр тал харилцан тохиролцон гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болох бөгөөд талуудад гэрээний 1 хувийг хадгалуулна.
- 1.3. Гэрээ нь 2021 оны 05-р сарын 14-ний өдрөөс 2022 оны 05-р сарын 14-ний өдөр хүртэл 1 жилийн хугацаанд хүчин төгөлдөр мөрдөгдөнө.
- 1.4. Аль нэг талын санаачлагаар гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж болох бөгөөд гэрээний нэгэн адил хүчин төгөлдөр үйлчилнэ.

Хоёр. Нутгийн захиргааны байгууллагын эрх, үүрэг

- 2.1. Хууль тогтоомж, дүрэм, журам, төрийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагаас гаргасан тогтоол, шийдвэрийг аж ахуйн нэгж, байгууллагад сурталчлах ажлыг зохион байгуулж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч төрийн үйлчилгээг хөнгөн шуурхай үзүүлнэ.
- 2.2. Газар ашиглах, эзэмших, ашигт малтмал эрэх, хайх, ашиглах үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага байгаль орчныг хамгаалах, түүний баялагийг зохистой ашиглах, нөхөн сэргээх талаар хууль тогтоомжинд заасан үүргээ хэрхэн биелүүлж байгаад хяналт тавьж, гарсан зөрчлийг таслан зогсоох арга хэмжээ авах.
- 2.3. Захиргааны байгууллага нь гэрээний хугацаанд аж ахуйн нэгж, байгууллагын нийгмийн хариуцлагын хүрээнд хийгдсэн аливаа үйл ажиллагааг орон нутгийн иргэдэд тухай бүр нь үнэн зөв мэдээлж ажиллах
- 2.4. Төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтарч сургалт, семинар, үзэсгэлэн худалдаа болон бусад арга хэмжээнд оролцуулах ажлыг зохион байгуулах

Гурав. Аж ахуйн нэгж, байгууллагын эрх, үүрэг

- 3.1. Аж ахуйн нэгж, байгууллага нь өөрийн үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомж, дүрэм, журам, төрийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагаас гаргасан тогтоол, шийдвэрийг чанд биелүүлж, олон нийтийг хамарсан арга хэмжээ болон нийгмийн дэг журмыг хангах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд идэвхи санаачлагатай оролцох
- 3.2. Аж ахуйн нэгж, байгууллага нь орчны 50м хүртэлх газрын ашиглалт хамгаалалт, цэвэрлэгээ, халтиргаа, гулгааг хариуцан тогтмол цэвэрлэх, мод, бут, зүлэг тарьж, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, орчны тохижилтод хувь нэмрээ оруулж, гаднах хаягаа гэрэлтдэг, товгор крилл үсгээр бичиж байршуулах, гэрэлтүүлгийг стандартын дагуу хийж гүйцэтгэх, хог хаягдлын гэрээ байгуулан ажиллах
- 3.3. Нийслэлийн агаарын бохирдлыг багасгах зорилтын хүрээнд өвлийн улиралд сэргээгдэх эрчим хүчний бие даасан үүсгүүр, стандартын шаардлага хангасан хийн болон цахилгаан халаагуур, бүрэн шаталттай шахмал түлш ашиглах
- 3.4. Зориулалтын (2-3 хоногийн багтаамжтай) хогийн савтай байж, бохир усны цооног, бие засах газрыг стандартын шаардлага хангасан хөрс бохирдуулахгүй байдлаар шийдэх
- 3.5. Орон нутгийн нийгмийн халамж дэмжлэг шаардлагатай өрх, иргэдэд чиглэсэн тодорхой үйл ажиллагааг санаачлан хэрэгжүүлэх
- 3.6. Дүүрэгт ажлын байрыг нэмэгдүүлж, ажиллах хүчний 80 хүртэлх хувьд дүүргийн харьяалалтай иргэдийг хамруулж, ажлын байраар хангах, мэргэжлийн сургалтад хамруулан, чадваржуулах ажлыг зохион байгуулж, ажиллагсдын хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл ахуйн нөхцөл

болон, тухайн дүүргийн иргэдийн аюулгүй байдлыг нэн тэргүүнд тавьж, ажлын байран дахь аюул эрсдлийг бууруулах, урьдчилан сэргийлэх чиглэлээр ажилтантай мэдээлэл солилцож, хамтран ажиллах

3.8. Ажилчдыг нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалд хуулийн дагуу цаг хугацаанд нь хамруулах

3.9. Насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалтыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллана. /Хөдөлмөрийн сайдын 2016 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн №36 дугаар тушаалаар батлагдсан/

Дөрөв. Гэрээ дуусгавар болох

Дараах тохиолдолд гэрээ дуусгавар болно. Үүнд:

4.1. Гэрээг хугацаанаас нь өмнө цуцлах талаар аль нэг тал нөгөө талдаа бичгээр мэдэгдсэн боловч нөгөө тал нь ажлын 14 хоногт багтаан асуудлыг шийдвэрлээгүй эсхүл хариу өгөөгүй тохиолдолд;

4.2. Гэрээний хугацаа дуусаж, цаашид сунгагдахгүй болсон.

4.3. Гэрээний үүргээ хангалтгүй биелүүлсэн тохиолдолд гэрээг сунгахгүй.

4.4. Давагдашгүй хүчин зүйл /тухайлбал: үер, гал түймэр, газар хөдлөлт зэрэг байгалийн гамшиг, халдварт өвчний тархалт, дайн байлдаан, зэвсэгт мөргөлдөөн, террорист үйлдэл, иргэдийн үймээн, нийтийг хамарсан ажил хаялт, эрх бүхий байгууллагаас гаргасан хорио цээр гэх мэт/-ийн нөхцөл байдлын шууд болон шууд бус үйлчлэлийн улмаас талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй тохиолдолд гэрээг хүчингүйд тооцно.

Тав. Нэмэлт нөхцөл

.....
.....

Зургаа. Гэрээний хариуцлага, дүгнэх

6.1. Талууд гэрээний биелэлтэд тавих хяналтыг хамтран хийж, оны эцэст үр дүнг тооцож гэрээг дүгнэнэ.

6.2. Дүүргийн ойн арга хэмжээ болон дүүргийн хөгжилд оруулах хөрөнгө оруулалтын ажлуудыг талууд харилцан зөвшилцөж, тухай бүрт нь шийдвэрлэн хамтран ажиллана.

6.3. Энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ хангалтгүй биелүүлсэн аж ахуйн нэгж, байгууллага нь Монгол Улсын "Зөрчлийн тухай", "Хог хаягдлын тухай", "Байгаль орчныг хамгаалах тухай" болон бусад холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ.

6.4. Холбогдох хууль тогтоомж, стандарт, гэрээгээр хүлээсэн үүргээ давтан зөрчсөн, иргэдийн эрх ашгийг ноцтой хохироосон нь тогтоогдсон нөхцөлд аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг холбогдох хуулийн байгууллагатай хамтран бүрэн зогсоох арга хэмжээ авна.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

ДУҮРГИЙГ ТӨЛӨӨЛЖ:
ХОТ ТӨЛӨВЛӨЛТ, ҮЙЛДВЭРЛЭЛ, НОГООН
ХӨГЖЛИЙН ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨРИЙН
УДИРДАГЧ БӨГӨӨД ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ *С.Тунгалаг* С.ТУНГАЛАГ
20... оны ... сарын ... өдөр

УТАС: 7023
ХУДАЛДАА, ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
ХЭЛТСИЙН ДАРГА *С.Тунгалаг* С.ТУНГАЛАГ
20... оны ... сарын ... өдөр

УТАС: 70233617

АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫГ
ТӨЛӨӨЛЖ:
УЛААНБААТАР ХОТ
"Мерси" ХХК-ийн
ЗАХИРАЛ *Т.Бархучи*
20... оны ... сарын ... өдөр
УТАС: 99020334

"....." ХХК-ИЙН
АЖИЛТАЙ
20... оны ... сарын ... өдөр

УТАС: